

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 15 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 28 минутад эхэлж, мөн өдрийн 20 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд хийж, нийт 09 цаг 42 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны төсвийн төсөл хэлэлцүүлэх тухай.	Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх нарт үүрэг болгов
2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дүн хэлэлцүүлэх тухай.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дүн хэлэлцэн дэмжиж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> цахим сайтад шивж, баталгаажуулан хугацаанд нь хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Ариунбилэг, тус хэлтсийн мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.
3	“Стандарттай Ховд” хөтөлбөрийн төсөл хэлэлцүүлэх тухай.	“Стандарттай Ховд” хөтөлбөрийн төслийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
4	Аймгийн газар зохион байгуулалтын 2020 оны гүйцэтгэл, 2021 оны төлөвлөгөөний төсөл хэлэлцүүлэх тухай.	Аймгийн газар зохион байгуулалтын 2020 оны гүйцэтгэл, 2021 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадралд үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР